



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын захиалгаар
Цэцэг сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан*

**ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ
ЗАРЦУУЛАЛТАНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Ховд хот

2016 оны 9 сар

Агуулга

Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	1
ҮАГ-ын харьяа Ховд аймгийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл	2
Тэргүүлэх аудитор Л.Галбадрах	Бүлэг 1.Төсөвт байгууллагуудын орлого бүрдүүлэлт. Оршил	3
Аудитын менежер А.Цэцэгсүрэн	Орон нутгийн орлогын бүрдүүлэлтэнд тавих хяналт сулаас татварын орлого 13,4 сая төгрөгөөр тасарчээ.	3
Ахлах аудитор Д.Нарантуул		4
Аудитор Д.Балжинням		5
Шинжээч Ц.Гантулга		6
		8
2016 оны 9 дүгээр сар	Бүлэг 2. Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалтын талаар	10
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn	Сумын дүнгээрээ төсвийн санхүүжилтийг баталсан дүнгээс 118,3 сая төгрөгөөр, өөрийн орлогыг 3,2 сая төгрөгөөр дутуу авчээ.	10
	Орон нутгийн хөрөнгө оруулалт, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд тавих хяналт хангалтгүй байна.	11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.	Бүлэг 3. Дотоод хяналтын талаар	12
	Аудитын дүгнэлт	13
ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймгийн Аудитын газар 3 давхар	Аудитын зөвлөмж	14
	Тэргүүлэх Аудиторын тушаал	15
	Акт албан шаардлагын товчоо	16
	Хавсралтууд.....	18
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:	21

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ААГ	Аймгийн аудитын газар
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	Нийгмийн Даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын албан татвар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Мян.төг	Мянган төгрөг

Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Хөшөөтийн уурхайг түшиглэн сүүлийн жилүүдэд кемп, үйлчилгээний төвүүд ихээхэн хэмжээгээр нэмэгдэж байхад орон нутгийн төсөвт орох орлого нэмэгдэхгүй байгаагаас үзэхэд орлогыг нэмэгдүүлэх талаарх санаачлага гарган ажилаагүйг илтгэж байна.

Сумын ИТХ-ын тэгүүлэгчдийн 2008 оны 12 сарын 09-ны өдрийн 12 тоот тогтоолоор төлбөрийн хэмжээ тогтоож байгалийн баялаг ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалаас авах төлбөр баталсан байна. Тус тогтоолын нэгжийн өртөгт өөрчлөлт оруулаагүй байгаа тул шинэчлэн нэмэгдүүлж тогтоох шаардлагатай байна.

Харин хог хаягдлын талаар 2015 оны 02 сарын 23-ны өдрийн 04 тогтоол баталж мөрдөж байна.

Цагаан эрэгт гэрээ байгуулан нөхөн сэргээлт хийсэн ажлын гүйцэтгэл хангалтгүй төдийгүй ТХГНТ хууль, БО-ны тухай хууль, Усны тухай хуулийг зөрчиж байна.

Гянтболд/волфрам/ гар аргаар олборлож эвдрэлд орсон Цагаан эрэг хэмээх газарт нөхөн сэргээлт хийлгэх саналыг Баян-Овоо багийн ИНХурал, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаан болон МУНБЦГ-ын хамгаалалтын захиргааны зүгээс гаргажээ.

Улмаар БОНХАЖЯ-ы Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын даргаас ирүүлсэн албан тоотын дагуу гар аргаар ашигт малтмал олборлогчид буюу “нинжа” нарын хууль бус үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 13 га газарт нөхөн сэргээлт хийх ажлын гэрээг Цэцэг сумын Засаг дарга болон МУНБЦГ-ын хамгаалалтын захиргааны дарга нар “Ашид алтай майнинг” ХХК-тай байгуулж 2015 оны 07 сарын 09-ээс 2015 оны 10 сарын 09-ний хооронд нөхөн сэргээлтийн ажлыг хийж дуусган хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн байна.



2015 онд тус компани гэрээний хугацаанд нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байхад ямар ч хариуцлага тооцохгүй, арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүйгээр дараагийн компанитай гэрээ байгуулж мөн газарт дахин нөхөн сэргээлтийн гэрээ байгуулжээ.



Сумын ИТХ-аар тогтоол гаргуулан 2016 онд Өүөүя Һой Һи Һауи -Овоо багийн нутаг Цагаан үдүя Һи Һауи Һүдүүе Һөөе Һауи “А Һауи Һауи Һауи” ХХК-тай Һи Һауи Һүдүүе Һөөе гэрээ байгуулжээ.

Аудитын явцад тус ажлыг гүйцэтгэлтэй танилцахад 2016 оны 10 сарын 9-ны өдөр нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгөхөөр гэрээ

Тус компани Ангиртын голын уснаас шланкаар ус татан вольфром угааж, ашигласан усыг буцаан голд цутгаж үрсгаж байгаа байдалтай байна.

A wide, muddy river flows through a valley, with a large, dark, forested hill in the background. The river is filled with brown, silty water and has a wide, flat bed of sand and silt. The surrounding landscape is a mix of green grass and brown, rocky soil. The sky is overcast and grey.

A wide, shallow reservoir or lake in a dry, hilly landscape under a cloudy sky. The water is calm and reflects the overcast sky. The surrounding terrain is arid and brown, with some low-lying vegetation. In the background, there are rolling hills and mountains. The foreground shows a dirt road or path leading towards the water.

Мөн тус газарт Мянган угалзатын БЦГ-ын байгаль хамгаалагч ажиллаж байгаа боловч үүргээ огт биелүүлээгүй байна.

5

**БҮЛЭГ 2. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН,
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР**

Сумын дүнгээрээ төсвийн санхүүжилтийг баталсан дүнгээс 118,3 сая төгрөгөөр, өөрийн орлогыг 3,2 сая төгрөгөөр дутуу авчээ.

Тус сумын төсөвт байгууллагууд 2015 онд Засгийн газар, аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын мөрийн хөтөлбөр болон бусад агентлаг, хэлтэс, сумын баг, албан байгууллагуудтай уялдуулан жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан биелэлтийг сар, улирал бүрээр тооцож ажилласан байна..

Сумын нийт дүнгээрээ 1686,8 сая төгрөгийн төсвийн санхүүжилт, 6,7 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэхээр батлуулж төсвийн санхүүжилтээр 1568,5 сая төгрөгийн батлуулж тайлант онд 1568,5 сая төгрөгийн санхүүжилт авч 3,5 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлжээ.

2.1. Сумын ИТХ-ын үйл ажиллагааны талаар:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хийх ажлын төлөвлөгөөг батлан төлөвлөгөөнд сум орон нутгийн эдийн засаг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд сумын засаг дарга, ЗДТГ, төрийн үйлчилгээний байгууллагын хариуцах чиг үүргийг тодорхой болгож, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч 2015 онд ИТХ-ын хуралдааныг 2 удаа хийж хийж дэвшүүлсэн ханган биелүүлж, тэргүүлэгчдийн хуралдааныг 8 удаа хийж ИТХ-ын 30 тогтоол гарсан байна. Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Сумын Хурлын даргатайгаа бүтээгдхүүний 3 ангид 13 бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийж, жилийн эцэст дүгнүүлэн 90,1 оноогоор “А” үнэлгээ авсан. Аймгийн ИТХ –аас 2015 оны ажлаа дүгнүүлж 3-р байранд оржээ.

Аудитаар ИТХ-аас сумын орлогын бүрдүүлэлтэнд тавих хяналтыг сайжруулж өмнөх тогтоолыг шинэчлэх зөвлөмж өглөө.

2.2 Сумын Засаг даргын үйл ажиллагааны талаар:

Сумын Засаг даргын 2015 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэн төрийн үйлчилгээг ард иргэд, албан байгууллагуудад ил тод шуурхай хүргэх, төр ард иргэдийн холбоог бэхжүүлэх зорилт тавин ажилласан байна. Нийт 29 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан.

ЗДТГ-ын дарга нь болон ЗДТГ-ын ажилчид тайланд онд бүтээгдэхүүн нийлүүлэлт үр дүнгийн гэрээ байгуулж хэрэгжүүлсэн ажлыг дүгнэн ажиллажээ.

Сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд сайжруулах шаардлагатай анхаарал хандуулах дараах асуудлууд байна

- Сумын Засаг даргын тамгын газрын тайланд 7,8 сая төгрөгийн өглөг, 7,9 сая төгрөгийн насжилт өндөртэй авлага байгаа бөгөөд тус авлагыг холбогдох эздээс шүүхэд өгч шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
- ЗДТГ-ын мэргэжилтэнүүд УБ хот болон аймагт томилолтоор ажиллахдаа ирсэн бичиг, удирдамж, илтгэх хуудас бичихгүйгээр томилолт авч хэвшжээ. Иймд энэ алдааг давтан гаргахгүй, явсан томилолтын үр дүнд үнддэслэн

зардал олгож төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

- Ажилчдын цалингийн картанд гарын үсэг зуруулаагүй, цалингийн карт хөтлөлт хангалтгүй байна.
- Өмнөх онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар улсын тэмдэгтийн хураамжийн тооцоог татварын байцаагч тухай бүр бодож хяналт тавих зөвлөмж өгсөн ч орлогыг хянахад наториат хийлгэсэн хүмүүсээр гарын үсэг зуруулаагүй, нийт тушаасан орлого хөтөлсөн дэвтрийн орлогоос илүү байна.
- Сум сурталчилах үйл СХС-гаас 1,9 сая, ОНХС-гаас 4,0 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан боловч анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, жагсаалт төдий зүйл байгаа тул албан шаардлага бичлээ.

Аудитаар ашгийн татвар суутгаагүй, амралт цалин давхардсантай холбоотой 332,9 мянган төгрөгийн төлбөрийн акт анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, тушаал шийдвэргүй мөнгө зарцуулсан, нөхөн төлбөрийн барьцаа хөрөнгийг зарцуулсан зэрэгтэй холбоотой 13583.6 мянган төгрөгийн алдааг залруулах албан шаардлага бичлээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалт, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд тавих хяналт хангалтгүй байна.

- Аймгийн хөрөнгө оруулалтаар 3,0 сая санхүүжилт авч булаг тохижуулах ажлыг Хажинга багт хэрэгжүүлсэн боловч хэрэгжүүлсэн ажлууд хулгайд алдагдсан, гүйцэтгэсэн ажлын үр дүн хангалтгүй байна. Аудитын хугацаанд төслийг хэрэгжүүлсэн багийн ахлагчийг холбогдох тайлан мэдээг авч ирэхийг шаардсанч аймагт байгаа нэрээр үзүүлсэнгүй.
- Байгууллагын хөрөнгийн бүртгэлд трактор 2, мотоцикл 4, ланд 1, УАЗ фургон 1, тусгай зориулалтын хог тээврийн машин 1, бүгд 9 автотээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Гэвч байгууллагын ажлын хэрэгцээнд албан хаагчид хувийн автотээврийн хэрэгсэлийг ашиглаж байгаа, бүртгэлд байгаа тээврийн хэрэгсэлүүдээс 2 трактор, ланд маркийн автомашинууд нь ажлын хэрэгцээнд ашиглах боломжгүй болжээ.
- 2013,2014 оны ОНХС-гийн санхүүжилтээр 98,5 сая төгрөгийн өртөгөөр ахуй үйлчилгээний төвийн барилга баригдаж ашиглалтанд хүлээн авсан хэдий ч өнөөдрийг хүртэл тус байрыг ашиглалт байхгүй байна. Барилгын дээврээс дусаал гоожсоноос таазны шохой урссан, обой хууларсан байдалтай байна. Мөн өмнөх онд ОНХС-гаар хийгдсэн гэрэлт цамхагийн гэрэл ажиллахгүй байгаа нь төсвийн хөрөнгийн өгөөжийг бууруулж байна. Иймд баталгаат хугацаа дуусахаас өмнө холбогдох байгууллагад хандан даруй асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
- Сумын хуучин ЗДТГ байрлаж байсан байрыг ямар нэгэн гэрээгүйгээр хувьд хүнд эзэмшүүлж ахуй үйлчилгээний төв болгон ашиглаж байгаа бөгөөд орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээсээр ашиглуулах гэрээ байгуулаагүй байгаа тул гэрээ байгуулан ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

2.3 Орон нутгийн Хөгжлийн сангийн талаар:

2015 онд ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар нийт 14 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд 1 ажлыг тендерээр, 1 ажлыг харьцуулалтын аргаар, олон нийтийн оролцооны аргаар 3, үлдсэн 9 ажлыг шууд гэрээ байгуулжээ. Сумын 2015 оны 3 дугаар сарын 5–ны өдрийн ИТХ-ын хуралдааны 06 тоот тогтоолоор сумын ОНХСанд 140,6 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 97,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, оны эхний үлдэгдэл 5,0 төгрөг тайлант онд 84,5 сая төгрөгийн зардал гаргаж оны эцэст 17,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

№	Байгууллагын нэр	Гүйлгээний утга	Урьд оны үлдэгдэл өр	сая.төг
				2015 оны ажил
1	Хөрс авто сервис	шатахуун	5.0	
2	Ар Си Эс Си	зурагны үнэ	4.0	
3	Д.Цогбадрах	гэрэлт цамхаг	1.1	
4	Хөрс авто сервис	шатахуун	10.6	
5	Ц.Шинэбаяр	агаарын шугам та	1.6	
6	Босоо гарьд	жишиг хороолол	10.0	
7	Н.Өлзий Д.Даваад	агаарын шугам татах		0.3
8	Ж.Бямбадорж	Ард Аюуш цогцол	3.3	
9	Н.Төмөр	Баяр наадам		5.0
10	НГГД Хажинга баг	Угаалгын ванн		2.6
11	Б.Шинэбаяр	Аймаг сум сурталчлах		4.0
12	ЭМТөв	Урсгал засвар		2.0
13	Босоо гарьд	жишиг хороолол	5.0	
14	Скайтон ХХК	интернет		30.0
18	ДҮН	84.50	40.6	43.9

2014 оны гүйцэтгэсэн ажилд 40,6 сая төгрөг зарцуулж, 3 дугаар сард сум сурталчлах үйл ажиллагаанд 4,0 сая төгрөгийг шийдвэргүй зарцуулсан байна.

2.4 Сум хөгжүүлэх сангийн талаар

Сум хөгжүүлэх сангийн оны эхний үлдэгдэл 38,8 сая төгрөг зээл зээлийн хүүний 17,0 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 90,1 сая төгрөгийн зарлага гаргаж тайлант онд 8 иргэн аж ахуйн нэгжид 49,2 сая төгрөгийн зээл олгосон боловч аймаг, сум сурталчлах болон улсын алдарт уяачид хүндэтгэх үзүүлэх үйл ажиллагаанд сангийн зээлийн хөрөнгөөс шийдвэргүйгээр 3,4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ.

2015 онд олгосон зээлийн хэрэгжилтийг хянахад дараах алдаа дутагдал байна.

- Т.Түвшинжаргалд олгосон тахианы аж ахуй байгуулах 5,0 сая төгрөгийн төсөл, Ж.Баяраагийн цагаан идээний 2,5 сая төгрөгийн төсөл, Уламжлалт эдлэл үйлдвэрлэлийн Б.Ундрахын төсөл, П.Хүрлээгийн авто угаалга дугуй засварын төсөл Л.Ганбаатарын блокны үйлдвэрлэлийн төсөл, У.Оюунтуяагийн 5,0 сая төгрөгийн мал угаалгын лабортарийн төслүүд амжилттай хэрэгжиж байна.
- С.Уламбаярт 5,0 сая төгрөгийн зээлийг шатахуун түгээх станцын тоног төхөөрөмжийн шинэчлэлд зээл олгосон нь СХС-гийн журмыг зөрчиж байгаа тул буцаан санд оруулах төлбөрийн акт бичлээ .
- Н.Төмөрт 20,0 сая төгрөгийн зээл олгож суманд үйлчилгээ явуулж байгаа иргэдэд материал нийлүүлэх төслүүд нь сум хөгжүүлэх сангийн зээлийн журмыг зөрчсөн байна.
- Өмнө онуудад олгосон зээлүүдийг хугацаандаа төлүүлөөгүй иргэдийг шүүхэд хандан эвлэрлийн гэрээ байгуулж төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авч байна.
- Өмнөх онуудад олгосон зээл үндсэн төлбөр зээлийн хүүгийн орлогоос 187,3 сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж зээлийн эргэлтэнд байх ёстой байтал тайланд онд 49,2 сая төгрөгийн зээл олгосон нь 26,2 хувьтай байна.

Сумын хэмжээнд нийт 200 гаруй сая төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэр бүрдүүлж орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх нөөц байгаа хэдий ч өмнөх зээл авсан иргэд төлбөрөө төлөөгүйтэй холбоотой олгогдсон зээлийн тоо, зээлийн эргэц хангалтгүй байна.

2.5 Ерөнхий 12 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн талаар

Тус сумын 12 жилийн бүрэн дунд сургууль 2014-2015 оны хичээлийн жилд “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд “Сурагч нэг бүрийн авьяасыг нээн илрүүлж, хөгжүүлэх” зорилт тавин олон төрлийн дугуйлан хичээллүүлж “Ном”, “Авьяас” хөтөлбөрт суурилсан сурагчдын авьяасыг хөгжүүлэх 18 сонгон дугуйлан хичээллүүлж, боловсролын шинэчлэлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан байна.

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр 501 хүүхэд, дүйцсэн хөтөлбөрт 24 суралцагч нийт 525 хүүхэд суралцаж байна. Боловсролын мэдээллийн нэгдсэн систем хэрэгжиж эхэлж байгаа нь сургуулиас гадуур хүүхэд байхгүй болгох үндсэн хөшүүрэг болсон ба хамран сургалт 100 хувьтай байна. Мөн дотуур байранд хамрагдвал зохих 59 сурагч хүсэлт гаргасанаас 100 хувь хамруулж ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс 590,5 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоор 0,6, сая, бүгд 591,1 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр улсын төсвөөс 577,4 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0,4, нэмэлт санхүүжилтийн дансаар Боловсролын газраас суурь боловсрол олгох сургалтын зардал 0,5 сумын давсан орлогоос 0,3 бүгд 578,6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Тайлант онд төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын болон орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр 595,1 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 577,8 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсвөө 17,3 сая төгрөгөөр дутуу санхүүжилт авсан байна

ЁЁӨ—ЁҮЁӨ:

- Багш ажиллагсадын үр дүнгийн урамшуулалыг сургуулийн захиралын шийдвэрээр байгуулагдсан баг сар улиралаар дүгнэн олгож байгаа боловч ажил тасалсан, сахилгын шийтгэл оногдуулсан албан тушаалтанд олгосон, багшийн өөрийн болон магадлан баталгаажуулалтад чиглэсэн хөндлөнгийн үнэлгээний материалууд байхгүй, хавтгайруулан олгож байгаа дутагдал илэрлээ.
- Зэргийн нэмэгдэл илүү олгосон, цалингын шатлал илүү олгосон, ур чадварын нэмэгдэл илүү олгосонтой холбоотой 291183 төгрөгийн акт, цалингийн шатлал дутуу тооцож олгосон, анги даалтын мөнгө дутуу олгосонтой холбоотой буцаан олгох 220835 төгрөгийн акт тус тус бичигдлээ
- Тайлант онд батлагдсан орон тоогоор ажиллах жижүүр, үйлчлэгч нарын тоог багасгаж хичээл зохицуулагч, заалны зохион байгуулагч гэсэн батлагдаагүй орон тоог бий болгон ажиллуулж байгаа нь төсвийн үр өгөөжийг бууруулсан байна.

- Дотуур байрны хүүхдийн хоолны цэс гаргаж батлуулдаггүй, өдөр бүрийн хоолны талон няравын хоолны материал тараасан түүвэр зөрүүтэй, хүнсний материал илүү зарлагадсан, хүүхэдийн ирц багатай үед өдөрт өгөх хоёр хоолны нэгийг өгдөг, 4 цагийн цай өгдөггүй, хүнсэнд нийлүүлж байгаа махны үнэ зах зээлийн үнээс өндөр, хүүхдийн хоол хүнс хадгалж байгаа агуулах склад эрүүл ахуйн шаардлага хангаагүй, агуулахын бүртгэл хөтлөөгүй зэрэг зөрчил дутагдал эдгээр зөрчил дутагдалтай холбоотой 250000 төгрөгийн төлбөрийн акт төлүүлэхээр бичлээ. Дээрх алдаатай холбоотой 18720,0 мянган төгрөгийн албан шаардлага бичлээ.
- Төрийн үйлчилгээний албан хаагчдад ажлын үр дүнг нь дүгнэ ур чадварын нэмэгдэл олгох Засгийн газрын 1995 оны 96 тоот тушаалын хэрэгжилт хангалтгүй байгуу тул ажлыг бодитоор дүгнэн амжилт гаргасан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохыг зөвлөмж болгов.
- Сургуулийн бага ангийн сурагчдад өгч байгаа үдийн цайны чанар муу, нэр төрөл цөөхөн, эмч, жижүүр багш нарын ирцийн бүртгэл шаардлага хангахгүй байгаа нь үдийн цай хөтөлбөрийн чанар болон хүүхдийн ирцэнд бүртгэлээр тавих хяналт сул байна. Шалгалтын явцад 09 сарын 8-ны өдрийн үдийн цайны хэрэгжилтэнд хяналт тавихад “Тэнгэрлэг шандас” ХХК-аас нийлүүлж байгаа еэвэн нь тендерээр нийлүүлэх 0,80 гр аас 10 гр дутуу, “Урд богос” ХХК-аас нийлүүлж байгаа цайны боорцогнь тендерээр нийлүүлэх 120 гр аас 10 гр дутуу байгаа тул 117,0 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигдлээ.
- Тухайн байгууллага нь оны эхэнд малчинтай гэрээ байгуулж ажиллаж байгаа боловч гэрээ дүгнэсэн акт байхгүй, тооллого тооцоог чанартай хийдэггүй туслах аж ахуйн орлогыг тооцож орлогоороо зарлагаа нөхөх зарчимаар ажилладаггүй зэргээс төсвийн үрэлгэн зардал гаргаж байна. жишээлбэл: 2015 онд малаас авах ашиг шимээс 1720000 төгрөгийн орлого оруулж харин зардалд цалин 4200000 төгрөг, шатахуунд 320000 төгрөг, тэжээлд 31000 төгрөг нийт төгрөгийн зардал гаргасан байгаагаас үзэхэд 2831000 төгрөгийн алдагдалыг төсөвт учруулж байна.Цаашид малчинг төсвөөс цалинжуулахыг зогсоож орлогоороо зардлаа нөхөх зарчмаар аж ахуйн тооцоон дээр ажиллах
- Цэцэг сумын сургууль нь шилэн дансны сайтад 2016 оны тухайн жилийн төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайлан дараа жилийн төсвийн төсөл,санхүүгийн тайлан хагас жилээр, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт,аудитын тайланд дүгнэлтэнд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэмнэлт хэтрэлт,түүний шалтгааны тайлбар зэрэг мэдээллүүдийг оруулсан байна. 2016 оны хагас жилийн тайлан, 5,0 сая төгрөгийн дээш орлогын мэдээ, дараа оны төсвийн төсөл зэрэг мэдээлэл оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай Монгол улсын хуулийн 1 дүгээр зүйл 6 дугаар зүйлийн 6.1.4,6.1.5 дах заалт МУ-ын Засгийн газрын 384 дүгээр тогтоолын 2 дахь заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг зөвлөж байна.

Аудитын явцад дээрх зөрчил дутагдалтай холбоотой төсөвт төвлөрүүлэх 1085,0 мян төгрөгийн, буцаан олгох 220,8 мян төгрөгийн нийт 1305855 төгрөгийн аёд 18720,0 мян төгрөгийн албан шаардлага аёд-дээжүү.

Цэцэг сумын сургууль 2015 онд дэвшүүлсэн зорилтоо ханган биелүүлж ажилласан боловч төсвийн зарцуулалтанд тавих хяналт дотоод хяналт сул байна.

2.6 Сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар

5 дугаар сард цэцэрлэгийн хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж 657 хүүхэд хамруулсан. Үүнээс 80% өвчлөлтэй гарсан учир эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Амны хөндийн эрүүл мэндийн сургалт 2 удаа явуулан 440 хүүхэд хамруулсан. 10 дугаар сард дахин үзлэгт хамруулахад өвчлөлтэй шүд 20% буурсан байна.

Цэцэрлэг 5-10 жил ажилласан багш нарыг Улаанбаатар хот, Завхан, Увс аймагт үндэсний сургалтанд хамруулсан. Бага ангий багш нарын бүс, аймаг улсын зөдөлгөөнд, давхардсан тоогоор 21 багш хамрагдаж, бага ангийн багш М.Нарантуяа улсад өөрийн арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн байна.

Сумын Цэцэрлэг нь “Бид хүүхдийг эрүүл биетэй саруул ухаантай сайн хүн болгох үндэсийг тавина” гэсэн зорилтыг тавин ажиллажээ.

Цэцэрлэгийн үйл ажиллагаанд дараах дутагдал байна.

- Цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцахад тогооч, туслах тогооч нь ажлын байранд ажлын хувцас өмсөөгүй, тухайн өдрийн хоолны дээжийг авч хадгалаагүй, устгасан тухай тэмдэглэл хөтлөөгүй, ангиудын ирцийн бүртгэлийг бүрэн хөтлөөгүй батлагдсан хоолны цэс мөрдөөгүй, тухайн өдрийн хоолны талон бичээгүй байна.
- Багш, туслах багш нарт цагийн бүртгэлд бүрэн бүртгээгүй илүү цаг олгосон, цагийн бүртгэл хөтлөлт хангалтгүй, үр дүнгийн урамшуулалыг ажлын үр дүнг бүрэн тооцож дүгнээгүй, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон, тушаал шийдвэргүй хүүхдийн баярын үйл ажиллагаанд зарцуулсан,
- Худалдан авсан шатахууныг орлого авч тайлан гаргаагүй шууд зардалд бичиж тайлагнасан байна.
- Хөшөөт салбарын цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж 2016 онд МоЭнКо ХХК-аас гадна дотор засвар тохижилт үйлчилгээ хийгдсэн боловч барилгын гаднах хана салхи шуурганд дахин ховхорч унасан, ангиудын талбай стандарт норм нормативаасаа бага байна.
- Эд хариуцагчийн сар бүр гаргасан тайланг нягтлан бодогч нь санхүүгийн программд материалын нэр төрөл бүрээр мэдээллээ бүрэн оруулаагүй нийт дүнгээр оруулсан нь материалын орлого зарцуулалтад тавих хяналт сул хичнээн нэр төрлийн бараа материал худалдан авч зарцуулж байгаа мэдээлэл авах боломжгүй тухайн өдрийн ирж байгаа хүүхдийн тооноос хамаарч зарим бүтээгдэхүүнийг олгодоггүй тогтмол хэмжээгээр олгож байна. Тухайлбал: талх, варень, молоко, мах зэрэг материалыг олгож байгаа нь БШСУЯ-аас баталсан норм нормативыг мөрдөөгүй байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянахад 2016 оны хагас жилийн тайлан баланс болон дараа жилийн төсвийн төсөл, 2015 оны хагас, бүтэн жилийн тайлан балансын мэдээллээ оруулж байршуулаагүй байна.

Аудитаар нийт 10818,5 мянган төгрөгний төлбөр, зөрчил илэрснээс 10345,6 мянган төгрөгний албан шаардлага, зарим бараа материалыг зах зээлийн үнээс өндөр ханшаар худалдан авсан, томилолтоор ажилласан тухай илтгэх болон томилолтын хуудасгүйгээр мөнгө олгосон, ажилчдад илүү цагийг зөрүүтэй бодож олгосонтой холбоотой 472,9 мянган төгрөгний төлбөрийн акт бичлээ.

2.7 Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар

Эрүүл мэндийн төвд 14 үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж тус бүрээр төлөвлөгөө гарган нийт 22 сургалт явуулан 2665 орчим хүн хамруулсан. Салбар зөвлөлийн хурал 2 удаа хийж төлөвлөгөө боловсруулан ажилласан. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх багийн эмч сувилагчийн оролцоо сэдэвт 16 сум хамарсан нөхөрсөг уулзалтыг 2 өдөр Норвегийн байгууллагатай хамтран зохион байгуулан 140 хүн оролцлоо. Жилийн хүрээнд 5 компант ажил зохион байгуулсан мөн дархлаажуулалтын талаар “Тарваганы тахлын” аянг 5,7 сард “Амны хандийн гарын ариун цэвэр” аянг 5,10 дугаар сард “Хүүхдийн хүчирхийлэл” аянг 4 дүгээр сард баг байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Эрүүл мэндийн төв нь 2015 онд улсын төсвөөс 232.8 сая, өөрийн орлогоор 0,7 сая бүгд 233,5 сая төгрөгийн санхүүжилттэйгээр 24 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулжээ.

Тус байгууллага нь хувиарлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан, ажилтнуудынхаа үр дүнгийн гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэж эмнэлгийн эрхлэгчийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн алдаа, оноог хэлэлцэж цаашид ажиллах зорилтоо хамт олноороо хэвшсэн шийдвэрлэж хэвшсэн зэрэг ололттой талууд байна.

Эмнэлгийн өөрийн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх үүднээс байгууллагадаа тодорхой хэмжээний /100 гаруй толгой / малыг тухайн малчинтай гэрээ байгуулж өсгөн үржүүлж, ашиг шимийг нь хүртээмжийг байна.

Дээрхи ололттой талууд байгаа хэдий ч дараахь асуудлуудад учир дутагдалтай байна.

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн биелэлт 2016 оны эхний 8 сарын байдлаар давхардсан тоогоор 89 мэдээлэл байршуулхаас 60 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж 29 мэдээллийг хугацаа хожимдуулж мэдээлсэн байна.
- Хүнсний материалын тендер шалгаруулалт, бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээний үндсэн хийгдэж байгаа боловч нийлүүлж байгаа материалын нэгжийн үнэ тухайн үеийн зах зээлийн үнэ болон орон нутгаас мөрдүүлхээр гаргасан жишиг үнээс өндөр үнээр нийлүүлж байгаа дутагдал байна.
- Тайлангийн жилд тус эмнэлэг аймгийн Эрүүл мэндийн газраас зарлагдсан тендерээр сумын ЭЭС-гаас 15588,8 мян.төг-ийн эм нийлүүлэгдэж 14555,4 мян.төг-ийн эм зарцуулж 2500,0 мян.төг-ийн эмийн үлдэгдэлтэй байна.

Дээрхи зарцуулсан эмийн зарцуулалтанд эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмчийн зүгээс тавих хяналт сайжруулахыг зөвлөмж болголоо.

Үүнтэй холбоотойгоор төмс, ямааны махны нийлүүлэлттэй холбоотой 238280 төгрөгийн акт бичлээ.

2.8 Сумын соёлын төвийн үйл ажиллагааны талаар

Тус сумын соёлын төв нь 2015 онд эрхлэгч, хөгжмийн багш, номын санч, техникч, үйлчлэгч, галч гэсэн орон тоотойгоор нь төрөөс соёлыг хөгжүүлэх талаар баримтлаж буй бодлого, Засгийн газрын хөтөлбөр, засаг даргын мөрийн хөтөлбөрт соёл урлагийн талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Соёлын төвийн ерөнхий менежер 2015 онд төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж үр дүнгийн гэрээгээ 98,3 хувиар ханган биелүүлэн “А” үнэлгээ авсан байна.

2015 онд Соёлын төв нь соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх, уран сайханчид болон ардын авъяастнуудын хүрээнд шинээр концерт найруулан тоглолт хийх, нийтийн цэнгээнт бүжиг явуулах, алдар тэмдэглэх, үдэшлэг уулзалт зохион байгуулах, хөдөөгийн багуудаар соёлын арга хэмжээг явуулах зэрэг арга хэмжээг явуулжээ.

Тус байгууллага нь тайлант онд улсын төсвөөс 51,6 сая, өөрийн орлогоор 5.0 сая нийт 56,6 сая төгрөгийн орлого бүрдүүлж зарцуулахаас гүйцэтгэлээр төсвөөс 50,2 өөрийн орлогоор 1.7 сая төгрөг нийт 51.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад 18 мэдээлэл хугацаа хэтрүүлсэн мэдээлэлийн баазад аудитын дүгнэлт, санхүүгийн тайлан, төсвийн хүрээний мэдэгдэл, 5,0 сая төгрөгөөс дээш орлогын гүйцэтгэл, төсвийн төсөөл, хандив тусламж мэдээлээгүй байна. 2016 оны 8 дугаар сарын мэдээлэлийг оруулаагүй байна.

Соёлын төвийн үндсэн үйл ажиллагааны нэг нь соёлын үйлчилгээ боловч үнэт цаасны тооцоо хэвлүүлэн дугаарлаж тооцоо бодоогүй бөгөөд нягтлан бодогч няравын тооцоог сар бүр бодоогүй тул 1,7 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.

2.9 Сумын эмийн эргэлтийн сангийн талаар:

Эмийн эргэлтийн сан нь Эрүүл мэндийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 297 тоот тушаалын хавсралтаар “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-аар зохицуулагдаж байна.

Энэ журмын 2.2-т “Бүх шатны Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд удирдах болон хяналтын зөвлөлийн тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.” 2.1-д...”суманд ЭЭС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий хяналтын зөвлөл байна.” 4.5.1-т “ЭЭС-ийн эрхлэгч нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай боломжийн үнэтэй эм, эмнэлгийн хэрэгслэлээр сумын эрүүл мэндийн төв, ард иргэдийг хангана” гэж заасан байна.

Тайлангийн хугацаанд сумын ЭЭС-нь Мөнхийн тун, Барагшун фарм, Монос трейд ХХК, Евро Ховд, Монпа трейд ХХК, Ховд Эм Импекс ХХК, МЭИК ХХК –

иудаас 20482,6 мян.төг-ийн эм худалдан авч 31588,3 мян.төг-ийн зарцуулалт хийж эмийн үнийн зөрүү 11105,7 мян.төг-өөр зарцуулсан тооцоо байна.

Суманд тендерээр нийлүүлэгдэж байгаа эм, ЭЭС-аас нийлүүлэгдэж байгаа эмийн бэлтгэлийг хоёр тусад нь тусгаарлаж тус тусын тооцоотой байхаар эрх зүйн зохицуулалт хийхээр зохион байгуулж ажиллах талаар аймгийн Эрүүл мэндийн газар, холбогдох байгууллагуудад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмж өглөө.

БҮЛЭГ 3. ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцаас сумын төрийн төрийн санд олгож Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий санхүүгийн дотоод хяналтыг Төрийн сангийн төлөөлөгч болон Санхүү албаны дарга хэрэгжүүлж хяналт тавьж байна.

Сумын Төрийн сангийн мэргэжилтэний гүйлгээг хянахад 7 удаагийн 1,8 сая төгрөгийн гүйлгээний баримт 1 дүгээр гарын үсэг дутуу, төлбөрийн баримтын шилжүүлгийн тоо зөрүүтэй, тамга дутуу, баримтыг үдэж архивлаагүй зэрэг алдаа байгааг залруулах зөвлөмжийг өглөө.

Сумдын нийт байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг авч үзвэл орон нутгийн нэгтгэл тайлан, сумын сургууль Хязгаарлалттай санал дүгнэлт, сумын цэцэрлэг, эрүүл мэндийн төв, сумын соёлын төв Зөрчилгүй санал дүгнэлт авчээ.

Сумын төсөвт байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн хүрээнд байгууллагын санхүү төсвийн мэдээллийг shilendans цахим хаягаар 2015, 2016 оны саруудын төсвийн гүйцэтгэл болон өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2016 оны төсвийн төсөл, мэдээлэлүүдийг оруулж байгаа ч зарим мэдээлэлийг бүрэн оруулаагүй хугацаа хоцроож оруулсан зэрэг дутагдал байна.

Сум хөгжүүлэх сан, ОНХС-гийн мэдээлэлийг оруулаагүй байгаа тул Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй албан тушаалтануудад хариуцлага тооцохыг Төсвийн Төвлөрүүлэн захирагчид зөвлөж байна.

2016 оны зарим сарын мэдээлэл хугацаа хоцроож байгаад дүгнэлт хийж хуульд заасан хугацаанд мэдээлэлээ оруулах шаардлагатай байна

Мэдээлэлийн технологийн эрин үед хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг иж бүрэн ашиглах шаардлагатай байна.

2015 онд Мобинеттэй гэрээ байгуулан сумдын байгууллагууд зарим өрх цахим сүлжээнд холбогдож мэдээлэлийг тухай бүр ашиглах боломжтой болжээ.

Сумын бүх төсөвт байгууллагууд санхүүгийн программ хангамж ашиглаж байгаа боловч бараа материалын тайланг иж бүрнээр программд оруулдаггүй, цалинг программ хангамж ашиглан боддоггүй зөрчил байна.

Орон нутгийн олон нийтийн ТВ /Ховд ТВ/, Орон нутгийн сонин /Ховдын толь сонин/, Брошюр, танилцуулга, бусад олон нийтийн ажил, уулзалт, сургалтаар дамжуулан олон нийтэд хүрэх хөтөлбөр боловсруулан хүргэж байна.

Аудитаар нийт 51,699,746 төгрөгний төлбөр зөрчил илэрсэнээс 2,350,559 төгрөгт акт, 44,349,187 төгрөгт албан шаардлага бичигдлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Тус сумын орон нутгийн төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж ажилласан боловч төсөвт байгууллагуудын үдийн цай, хоолны зарцуулалтанд тавих дотоод хяналт сул, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд илэрсэн төлбөр, зөрчилд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Сүхбаатар, Засаг дарга Д.Цогбадрах, Тамгын газрын дарга Я.Болдбаатар нарт дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

1. Сумын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах

2. ОНХС, хөрөнгө оруулалтаар хангалтгүй хэрэгжсэн ажлуудыг гүйцэтгэлийг баталгаат хугацаанд холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх

4. Сум хөгжүүлэх сангийн зээлийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, зээлээ графикт хугацаандаа төлөөгүй, зориулалт бусаар зарцуулж буй иргэдийн зээлийг буцаан татаж зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх

5. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн мэдээлэл тавих албан тушаалтануудад хариуцлага тооцох

6. Сумын хүн эмнэлэгийн байр муудсан амрах байр, мооргийн байр байхгүйгээс эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэхэд хүндрэл тулгарч эмчилгээ үйлчилгээ явуулахад хүндрэлтэй байгаа тул холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх

7. Аудитаар илэрсэн алдаа дутагдлыг дахин гаргахгүй байж, зөвлөмжөөр өгсөн үүргийг биелүүлэн ажиллах

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

АУДИТОР

Д.БАЛЖИННЯМ

ШИНЖЭЭЧ

Ц.ГАНТУЛГА

Тэргүүлэх Аудиторын тушаал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 19 өдөр Дугаар 24 Холд хэл

Аудитын тайлан, зөвлөмж, акт,
албан шаардлага батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 тоот тушаалаар баталсан "гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, 2009 оны 47 тоот тушаалаар баталсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын дэргэдэх зөвлөлийн 2016 оны 09 сарын 19-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дарви, Цэцэг сумдын төсөвт байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Дарви сумын Засаг дарга Д.Ган-Эрдэнэ-д ДААЛГАХ нь:
 - 2.1 Тус сумын хэмжээнд бүртгэлтэй мөртлөө байхгүй байгаа 73 авто тээврийн хэрэгсэл байхгүй мөртлөө татварын төлөвлөгөөнд тусгагдаж байгааг судлаж шийдвэрлэх
 - 2.2 Алтай Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто заманд ашиглагдаж байгаа байгалийн баялаг түгээмэл тархацтай ашигт малтмалын татвар тооцон авч сумын төсвийн орлогоо бүрдүүлэх
 - 2.3 Малын хишиг болон Хишигсүрэг мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд 12,9 сая төгрөгний явуулын мал угаах ванн орлого авах.
 - 2.4 СХСангаас авсан зээлээ бүрэн төлөөгүй байгаа иргэдээс зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл болох 93,1 сая төгрөгийг төлүүлэн авч дараагийн зээлдэгч нарт олгох
 - 2.5 Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт ашиглалтыг сайжруулан, түрээслүүлсэн хөрөнгийн орлогыг цаг тухай бүрт нь данс тушаалгаж байх

2.6 Эмийн эргэлтийн нөөцийг нэмэгдүүлэн иргэдэд хөнгөлөлттэй эмийн жороор үйлчлэх өр төлбөрийг барагдуулан ажиллах тал дээр анхаарч ажиллах

3. Цэцэг сумын Засаг дарга Д.Цогбадрах-д ДААЛГАХ нь:

3.1. Сумын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах

3.2. ОНХС, хөрөнгө оруулалтаар хангалтгүй хэрэгжсэн ажлуудыг гүйцэтгэлийг баталгаат хугацаанд холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх

3.3. Сум хөгжүүлэх сангийн зээлийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, зээлээ графикт хугацаандаа төлөөгүй, зориулалт бусаар зарцуулж буй иргэдийн зээлийг буцаан татаж зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх

3.4. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн мэдээлэл тавих албан тушаалтануудад хариуцлага тооцох

3.5. Сумын хүн эмнэлэгийн байр муудсан амрах байр, мооргийн байр байхгүйгээс эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэхэд хүндрэл тулгарч эмчилгээ үйлчилгээ явуулахад хүндрэлтэй байгаа тул холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх

4. Гүйцэтгэлийн аудитын зөвлөмж тавьсан акт, албан шаардлагыг барагдуулж дүнг 10 сарын 10-ны дотор танилцуулахыг аудит хийсэн аудитор, шинжээч нарт хариуцуулсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЦОГБАДРАХ



